



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/232

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 147 дугаар
цэцэрлэгийн хөрөнгийг данснаас дансанд
шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 6 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хангамжийн материалын дансанд бүртгэлтэй нийт 9,550,800.00 (есөн сая таван зуун тавин мянга найман зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг барилга байгууламж дансанд, шилжүүлэн бүртгэхийг Баянзүрх дүүргийн 147 дугаар цэцэрлэг (Х.Чимэдцэрэн) -т зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн 147 дугаар цэцэрлэг (Х.Чимэдцэрэн) -т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500805



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
 2024 оны 11 дугаар сарын 11-ны өдрийн
 1183/2024 дугаар тушаалын хавсралт

Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: НЕБ-ын 147-р сургууль

| д/д | Хөрөнгийн нэр | Марк, дугаар, үзүүлэлт | Ашигласан БИЖ | Чанар байдал | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Бүртгэх анхны | | Хуримтлагдсан элэгдэл /2022 оны ... сарын ...өдрийн байдлаар/ | Үлдэгдэл үнэ | Дансны нэр | |
|-----|---------------|------------------------|---------------|--------------|-------------|------------|---------------|--------------|---|--------------|-------------------|--------------------|
| | | | | | | | Нэгж үнэ | Нийт үнэ | | | Шилжүүлэх данс | Бүртгэх данс |
| 1 | Торон хашаа | Төмөр торон хашаа | 2 | сайн | м2 | 168 | 56,850.00 | 9,550,800.00 | - | 9,550,800.00 | Эргэлтийн хөрөнгө | Барилга байгууламж |
| | Дүн | | | | | | | 9,550,800.00 | | | | |